



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/554

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXVIII хуралдааны XXVIII/37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүүхдийн “Уран дөш зуслан”-гийн үйл ажиллагааны үндсэн хөрөнгө болон ахуйн бусад материалд шаардагдах зардалд 30,000,000 (гучин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг “аймгийн Засаг даргын Тамгын газрын Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого удирдлага хөтөлбөр зориулалт”-аас гаргаж зарцуулахыг ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Хүүхдийн “Уран дөш зуслан”-гийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг үр дүнтэй зарцуулж, мэдээллээр хангаж ажиллахыг хүүхдийн “Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Шагай), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ